

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх мэдээлэл

*Аймгийн Аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.БОЛОРТУУЛ*

Чойбалсан хот 2017.03.06

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл: Төсвийн цагалбар

д/д	Хуулийн заалт	Төсвийн захирагчийн нэрс	Төрийн аудитын байгууллагад ирүүлэх хугацаа	Төрийн аудитын байгууллага дүгнэлтийг гардуулах хугацаа
1	8.9.1	төсвийн шууд захирагч	01-р сарын 25-ны дотор	02-р сарын 25-ны дотор
2	8.9.3	сумын Төрийн сан буюу Засаг дарга	03-р сарын 05-ны дотор	03-р сарын 25-ны дотор
3	8.9.3	аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч	04-р сарын 01-ны дотор	04-р сарын 20-ны дотор
4	8.9.8	төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	02-р сарын 15-ны дотор	03-р сарын 15-ны дотор

Санхүүгийн тайлангийн аудит

- Төсвийн хуульд заасан богино хугацаанд хязгаарлагдмал нөөцөөр орон нутгийн хэмжээн дэх төсвийн болон орон нутгийн, төрийн өмчит байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулан, аудитын дүгнэлт өгөх шаардлага тулгардаг.
- Хуулиар хүлээсэн дээрх шаардлагыг илүү үр нөлөөтэй биелүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитыг улсын хэмжээнд богино хугацаанд нэгтгэж, удирдах, зохион байгуулах шаардлага зүй ёсоор урган гарсан.
- Санхүүгийн тайлангийн аудит хийх стандартчлагдсан арга зүйг боловсруулах, хөгжүүлэх, аудитад нэвтрүүлэх ажлыг “Смарт грийн технологи” ХХК-тай хамтран цахим хэлбэрт шилжүүлэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС)-ээр аудитыг цахим хэлбэрээр хийн, хянан, улсын хэмжээнд нэгтгэдэг болсон.

СТА-д итгэл үзүүлэх журам

“Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын дараах шаардлагыг хангасан 20 байгууллагад батламжийг гардуулан өгсөн.

- Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дотоод хяналт сайтай нь тогтоогдож 3 жил дараалан зөрчилгүй дүгнэлт авсан.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж биелэлтийг ирүүлсэн.
- Төсвийн тухай, Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийг мөрдөж ажилласан.
- Сүүлийн 3 жилд улсын болон орон нутгийн төсвийг хэмнэж, зориулалтын дагуу зарцуулсан, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл багатай.
- Тайлант хугацаанд бүтэц, зохон байгуулалтын өөрчлөлт ороогүй.
- Байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогч тогтвор суурьшилтай ажилласан.
- НББ-ийн бодлогын баримт бичиг болон санхүү, бүртгэлийн програм хангамжид өөрчлөлт ороогүй.
- Санхүүгийн тайлан болон бусад аудит хийгдснээс хойш хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүмжлэлд өртөөгүй.
- Олон нийтийн болон хууль тогтоох байгууллагын анхаарал татсан бусад асуудал хөндөгдөөгүй.


Завсрын аудитаар...

- Төрийн аудитын тухай хууль түүнээс үүдэн гарсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9-д заасны дагуу 110 байгууллагад завсрын аудитыг хийсэн.
- Эдгээр байгууллагаас 9 байгууллага хуулийн хугацаанд тайлангаа ирүүлж, 72 байгууллага хуульд заасан хугацаанаас хоцроож, 29 байгууллага санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй байна.

Төсвийн шууд захирагч

- Төсвийн шууд захирагчийн 71 байгууллагын санхүүгийн тайланг СТАУС-ээр баталгаажуулан, нийт 35.1 сая төгрөгийн өртөг, 3200хүн/цаг зарцуулан ажиллалаа.
- Аудитад хамрагдсан төсвийн шууд захирагчийн 70 байгууллагад зөрчилгүй, Хөлөнбуйр сумын ЗДТГ-т хязгаарлалттай санал дүгнэлт өгөөд байна.
- Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,1 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 3.8 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулан, 22,4 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоон, 3.5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гарган ирүүлж байх 43 албан шаардлага өгч ажиллав.

Нийт зөрчлийг графикаар харуулбал:



Төрийн аудитын тухай хуулинд...

- Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Засгийн газар болон бусад байгууллагууд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргаж Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”

Төсвийн тухай хуулинд

- Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ...”

Хариуцлага тооцуулах санал

- Төрийн Аудитын тухай хуульд заасны дагуу хуулийн хугацаа хоцроон ирүүлсэн орон нутгийн төсөвт 10 байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцуулах саналыг хүргүүлээд байна.
 - Үүнд: Матад сумын ЗДТГ, Матад сумын Сургууль, Халхгол сумын ЗДТГ, Халхгол сумын ОНХС, Чойбалсан сумын ЗДТГ, Баянтүмэн сумын ЗДТГ, Баяндун сумын ЕБС, Гурванзагал сумын ЗДТГ, Цагаан-Овоо сумын ЗДТГ, Халамжийн сан

Дүгнэлт

- Төсвийн шууд захирагч нар санхүүгийн тайлангаа Монгол Улсын Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлэхгүй байгаа шалтгааныг авч үзэхэд бүтэц орон тооны өөрчлөлт, шинэ томилгоо, удирдах ажилтны хуулийн мэдлэг дутмаг, хайхрамжгүй байдлаас үүдэлтэй гэж үзэж байна.

**АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА
БҮХЭНД БАЯРЛАЛАА.**